

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД,  
САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2021 оны ....дугаар сарын  
.....-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар

**ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ**

Тариалангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6 дахь хэсгийг үндэслэн  
ТУШААХ нь:

1."Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн  
үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх  
журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн  
үйлдвэрийн яам, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Журам батлах тухай Хүнс, хөдөө аж ахуй,  
хөнгөн үйлдвэрийн сайд, Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 26-ний өдрийн  
290/А-504 дүгээр хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН САЙД

САНГИЙН САЙД

З. МЭНДСАЙХАН

Ч.ХҮРЭЛБААТАР

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн  
сайд, Сангийн сайдын 2021 оны  
..... дүгээр хамтарсан тушаалын  
хавсралт

**ТАРИАЛАНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЭЛЖ БАЙГАА ИРГЭН,  
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛДВЭРЛЭСЭН БҮТЭЭГДЭХҮҮНД МӨНГӨН  
УРАМШУУЛАЛ ОЛГОХ, МӨНГӨН БУС ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар хүн амыг эх орны үйлдвэрийн эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах зорилгоор улаанбуудайн тариалан эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал болон мөнгөн бус дэмжлэг үзүүлэх, бусад бүтээгдэхүүнд мөнгөн бус дэмжлэг үзүүлэхэд зориулсан хөрөнгийг зарцуулах, тайлагнах, хяналт тавихтай холбоотойгоор үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Урамшуулалд хамрагдах бүтээгдэхүүнд олгох мөнгөн урамшууллын хэмжээ, үзүүлэх мөнгөн бус дэмжлэгийн төрөл, тоо хэмжээ, олгох нөхцөл, хэлбэрийг тогтоох шийдвэр гарахаас өмнө олон нийтэд урьдчилан зарлах, мэдээлэх, аливаа амлалт өгч үл болно.

1.3 Энэхүү журмын 4.1, 5.1 -д заасан шаардлагуудыг хангасан хүсэлт, баримт материалыг үндэслэн тариалангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн (цаашид “Сайд” гэх)-ий тушаалаар мөнгөн урамшуулал олгох болон мөнгөн бус дэмжлэг үзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

1.4 Мөнгөн урамшуулал олгох болон мөнгөн бус дэмжлэг үзүүлэх хөрөнгийг Сайдын шийдвэрийг үндэслэн тус яамны холбогдох байгууллага, нэгж хариуцаж шилжүүлэн олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох данс нь Төрийн санд бүртгэгдсэн байна.

1.5 Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний харъяа байгууллагууд тариалан эрхлэгчдэд зээл олгох тохиолдолд урамшуулалд олгосон мөнгөн болон мөнгөн бус хөрөнгийг зээлийн барьцаа болгож үл болно.

1.6 Гадаад орны зээл, хандив, буцалтгүй тусламжийг тухайн орны гэрээ, санамж бичигт өөрөөр заагаагүй бол Засгийн газрын тогтоолыг үндэслэн мөнгөн урамшуулал болон мөнгөн бус дэмжлэгийг санхүүжүүлэх эх үүсвэр болгож болно.

**Хоёр. Дэмжлэг, урамшууллын хөрөнгийн эх үүсвэр, зориулалт**

2.1.Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд олгох мөнгөн урамшуулалд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг санхүүжүүлэх асуудлыг Төсвийн тухай хуульд заасан төсвийн цаглабарын

дагуу санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, Сайдын төсвийн багцад хуваарилан батлуулна.

2.2. Мөнгөн болон мөнгөн бус дэмжлэгийг жилийн батлагдсан төсөвт багтаан төрөөс дэмжих зайлшгүй шаардлагатай байгаа тариалангийн бүтээгдэхүүнд олгох бөгөөд тухайн тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шаардагдах орцуудын хэрэглээ, шаардлага, үйлдвэрлэсэн хэмжээ, зах зээл дэх эрэлт, үнийн өсөлтийг харгалзан олгоно.

2.3. Урамшуулал болон дэмжлэгийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, тайлагнах үйл ажиллагаанд тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

### **Гурав. Бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх**

3.1. Энэхүү журамд заасан шаардлагуудыг хангасан, байгаль орчинд ээлтэй, түүний нөөц баялгийг хамгаалсан зохистой дэвшилтэт техник, технологи ашиглан нэгжээс хураан авах ургацыг нэмэгдүүлж, тогтвортой үйлдвэрлэл эрхлэн, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлж, хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд хувь нэмэрээ оруулсан тариалан эрхлэгчийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгож мөнгөн бус дэмжлэг үзүүлнэ.

3.2 Тариалангийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн тухайн жилийн ургацаас Дотоодын гурилын үйлдвэр болон Хөдөө аж ахуйг дэмжих сан, Улсын нөөцийн салбарт нийлүүлсэн “MNS 0097:2010- Хүнсний буудай. Техникийн ерөнхий шаардлага” стандартыг хангасан хүнсний улаанбуудайн тонн тутамд 100.000,0 /нэг зуун мянга/ хүртэл төгрөгийн мөнгөн урамшуулал олгоно.

3.3 Баруун болон зүүн бүсэд улаанбуудайн үйлдвэрлэл эрхэлж буй иргэн, хуулийн этгээдийн дотоодын гурилын үйлдвэр болон Хөдөө аж ахуйг дэмжих сан, Улсын нөөцийн салбарт нийлүүлсэн “MNS 0097:2010 Хүнсний буудай. Техникийн ерөнхий шаардлага” стандартыг хангасан хүнсний улаанбуудайн нэг тонн тутамд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэхүү журмын 3.2-д заасан мөнгөн урамшууллын хэмжээнээс 50 хувиар нэмэгдүүлэн тооцно.

3.4 Улаанбуудайн үр үйлдвэрлэлийг дэмжих, нутагшсан сортын үрээр тариалалт хийж ургацыг нэмэгдүүлэх, сортын үрийн чанар, хангамжийг сайжруулах зорилгоор улаанбуудайн нутагшсан сортын элит болон 1 дүгээр үржүүлгийн үр үржүүлж Хөдөө аж ахуйг дэмжих сан, Улсын үрийн нөөцийн салбар болон тариалан бүхий аж ахуйн нэгж, иргэдэд нийлүүлсэн “MNS 0246: 2010 Үрийн буудай. Сортын болон үрийн чанар. Ерөнхий шаардлага” стандартыг хангасан улаанбуудайн элит үрийн тонн тутамд 300.000 /Гурван зуун мянга/ төгрөг, 1 дүгээр үржүүлгийн үрийн тонн тутамд 150.000,0 / нэг зуун тавин мянга/ төгрөгийн мөнгөн урамшуулал олгоно.

3.5 Стратегийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн гурил үйлдвэрлэлд нийлүүлсэн, стандартын шаардлага хангасан хүнсний улаанбуудай, Улсын нөөцийн салбар, Хөдөө аж ахуйг дэмжих сан болон тариалан бүхий аж ахуйн нэгж, иргэдэд нийлүүлсэн улаанбуудайн элит болон 1 дүгээр үржүүлгийн үрийн мөнгөн урамшууллыг Хүнс Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний

(цаашид “сайд” гэх) шийдвэрийг үндэслэн нийлүүлсэн хүнсний улаанбуудай болон үрийн улаанбуудайн нэгж хэмжээнд тооцож олгоно.

3.6. Газар тариалангийн зориулалттай техник, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслэл, таримлын үр үрслэг, суулгац, шатахуун, бордоо, ургамал хамгааллын бодис, услалтын систем, усалгааны техник, тоног төхөөрөмж, зоорь, агуулах, үтрэмийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, зуны болон өвлийн хүлэмж, тариалангийн талбайн хашаажуулалт, хөрсний үржил шимийг тодорхойлох шинжилгээ болон уур амьсгалд дасан зохицсон ухаалаг газар тариаланг хөгжүүлэхэд шаардагдах бусад хэрэгслэлийн орцуудад мөнгөн бус дэмжлэг үзүүлнэ.

3.7 Мөнгөн бус дэмжлэгийн хэлбэр, тоо хэмжээ, тооцооны үнэ, төлбөр төлөх хугацаа, хүү, хөнгөлөлтийн нөхцөлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын шийдвэрээр тогтоож хэрэгжүүлэх бөгөөд зах зээлийн үнээс хямд байна.

3.8 Стандартын шаардлага хангасан стратегийн бүтээгдэхүүн болох хүнсний улаанбуудайг гурил үйлдвэрлэх зорилгоор нийлүүлсэн тариалан эрхлэгч нар мөнгөн урамшуулал болон мөнгөн бус дэмжлэгт хамрагдах, бусад тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа тариалан эрхлэгч нар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүндээ мөнгөн бус дэмжлэг авах тухай хүсэлт гаргана.

#### **Дөрөв. Мөнгөн урамшуулалд хамрагдахад тавигдах шалгуур үзүүлэлтүүд:**

4.1. Мөнгөн урамшуулалд хамрагдах тариалан эрхлэгчид нь дараах шаардлага, шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байна. Үүнд:

4.1.1 Тариалсан талбайн мэдээг таримлын төрөл тус бүрээр тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний дотор, бэлтгэсэн уриншийн дүнг 09 дүгээр сарын 15-ны дотор, хураан авсан ургацын дүнг таримлын төрөл тус бүрээр 12 дугаар сарын 01-ний дотор тус тус гаргаж харъяа сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан ажилтанд өгч, улсын нэгдсэн мэдээ тайланд үнэн зөв тусгуулсан байх;

4.1.2 Нийлүүлсэн бүтээгдэхүүнийг итгэмжлэл бүхий лабараторт шинжлүүлж, хүнсний буудайнд шинжилгээний дүн, үрийн улаанбуудайнд Улсын байцаагчийн дүгнэлт тус тус гаргуулсан байх,

4.1.3 Тариалан эрхлэгч иргэн, хуулийн этгээд нь улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэний үнэмлэхийн хуулбар, харилцагч банк болон дансны дугаараа сумын Засаг даргын тамгын газрын Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан ажилтанд өгч бүртгэлд оруулсан байх;

4.1.4 Нийлүүлсэн болон худалдан борлуулсан бүтээгдэхүүнийхээ тооцоог нийлүүлэгч байгууллагатай хийж Татварын цахим төлбөрийн баримтын системээр дамжуулан баталгаажуулсан байх;

4.1.5 Санхүүгийн болон татварын тайланг хуульд заасан хугацаанд нь тайлагнасан байх,

4.1.6 Сумын засаг даргын тамгын газрын Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан ажилтан нь тариаланчдын ирүүлсэн тариалсан талбай, хураан авсан ургац, боловсруулсан уриншийн талаархи мэдээллийг нэгтгэн, сумын удирдлагад танилцуулж хянуулан Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Үндэсний статистикийн хороо болон Хөдөө аж ахуйг дэмжих сангийн мэдээллийн санд оруулж баталгаажуулсан байх,

#### **Тав. Мөнгөн бус дэмжлэгт хамрагдахад тавигдах шалгуур үзүүлэлтүүд:**

5.1. Мөнгөн бус дэмжлэгт хамрагдах тариалан эрхлэгчид нь дараах шаардлага, шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байна. Үүнд:

5.1.1 Эзэмшиж буй тариалангийн талбайн хөрсний үржил шим нь Тариалангийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан шаардлагуудыг хангасан байх;

5.1.2 Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг сайжруулах, элэгдэл эвдрэлийг бууруулах, усны найрлага, чанарыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх (сэлгээний таримал тариалсан, ногоон бордуурт уринш, нийлмэл, эрдэс болон органик бордооны зохистой хэрэглээ, ойн зурвас, хашаажуулалт гэх мэт);

5.1.3 Ургамал хамгааллын арга хэмжээнд байгальд ээлтэй ургамал хамгааллын цогц арга, газар тариалангийн зохистой дадал нэвтрүүлсэн, талбайн түүхийн дэвтэр, гарал үүслийн гэрчилгээтэй байх;

5.1.4 Мэргэжлийн хөдөө аж ахуйн инженер, агрономчтай байх;

5.1.5 Бүтээгдэхүүний тариалсан талбай, хураасан ургац, бэлтгэсэн уринш болон техникийн бэлэн байдлын талаарх мэдээллийг сум, дүүргийн Засаг даргын тамгийн газарт тогтмол гаргаж өгсөн байх;

5.1.6 Өөрсдийн эзэмшилийн болон өмчлөлийн трактор, хөдөө аж ахуйн машин, тоног төхөөрөмж, зоорь, үтрэм, агуулах, элеватор, усалтын системийг паспортжуулан харьяа Хүнс, хөдөө аж ахуйн газарт бүртгүүлж тооллогод хамруулсан байх;

5.1.7 Орон нутгийн иргэдийг ажлын байраар хангасан байдал.

#### **Зургаа: Урамшууллын төлбөр тооцоо**

6.1 Урамшууллыг Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийн дагуу урамшуулалд хамрагдах тариалан эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн нэрийн дансанд төрийн сангийн дансаар дамжуулан шилжүүлнэ.

6.2 Тариалан эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн дансанд шилжүүлсэн урамшуулал нь нэр данс зөрүү, данс хаагдсаны улмаас буцаагдсан тохиолдолд залруулах дансны жагсаалтыг яам холбогдох аймаг, нийслэл, сум дүүргийн Хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллагад хүргүүлж, дансны мэдээллийг 14 хоногт залруулах арга хэмжээ авна.

6.3.Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харъяа холбогдох байгууллага нь Сайдын тушаалын хавсралтад заасан хуваарь, хэмжээний дагуу мөнгөн бус дэмжлэгт хамрагдсан иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан хуваарилах ажлыг зохион байгуулна.

6.4.Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулсан ажлын хэсэг мөнгөн бус дэмжлэгт олгох барааг нийлүүлэх ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу зохион байгуулна. Сайдын тушаалаар баталсан мөнгөн бус дэмжлэгээр олгох барааны нэр төрөл, тоо хэмжээ, нөхцлийг ажлын хэсэг өөрчлөхгүй.

6.5.Тариалан эрхлэгчдэд олгосон мөнгөн бус дэмжлэгүүдийн чанар, ашиглалт, баталгааны хугацаанд Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж ажиллана.

### **Долоо. Хөрөнгийг зарцуулах**

7.1.Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харъяа холбогдох байгууллага нь мөнгөн урамшуулал олгох болон мөнгөн бус дэмжлэг үзүүлэх тухай Сайдын тушаалыг холбогдох материалын хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

7.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага материалыг хянан үзэж нийт урамшуулалд хамрагдах хөрөнгийн эрх болон мөнгөн бус дэмжлэг үзүүлэхтэй холбоотой бусад эрхийг нээж тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулагатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг үндэслэн дараах шилжүүлгээс аль тохирохыг хийнэ. Үүнд:

7.2.1.Мөнгөн урамшуулал олгох болон мөнгөн бус дэмжлэгт хамрагдахад шаардагдах нийт хөрөнгийг Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харъяа холбогдох байгууллагын Төрийн сан дахь харилцах дансанд шилжүүлнэ.

7.2.2.Хэрэв тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу Сангийн яаманд өглөгтэй ба тэрхүү өглөгийг урамшуулал авах тариалан эрхлэгчид зээлдүүлсэн бол урамшууллын мөнгөнөөс зохих авлагыг суутган шилжүүлнэ.

7.2.3.Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харъяа холбогдох байгууллага нь төсвөөс олгосон санхүүжилтийг тариалан эрхлэгчид бүрэн олгох ба урамшуулал авч буй тариалан эрхлэгч нь дээрх байгууллагад гэрээгээр хүлээсэн өглөгтэй бол өглөгийг урамшууллын мөнгөнөөс суутган авч болно.

### **Найм. Тайлагнах, хяналт тавих**

8.1.Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харъяа холбогдох байгууллага, нэгж нь урамшуулал болон мөнгөн бус дэмжлэгт хамрагдсан иргэн, хуулийн этгээдийн энэхүү журмын 4.1, 5.1-д заасны дагуу бүрдүүлсэн баримт,

материал болон холбогдох бусад байгууллагаас хянаж, баталгаажуулсан шийдвэрийн хамт архивын нэгж болгон хадгална.

8.2.Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харъяа холбогдох байгууллага, нэгж нь тухайн онд урамшуулал болон мөнгөн бус дэмжлэгт хамрагдсан тариалан эрхлэгчдийн бүртгэл, хөрөнгө зарцуулалтын мэдээ тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулагад тус тус хүргүүлнэ.

8.3.Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харъяа холбогдох байгууллага нь жил бүрийн мөнгөн урамшуулалд олгосон болон мөнгөн бус дэмжлэгт зориулсан хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн тайлан тэнцэлд тухайн тайланг гарсны дараа жилийн 2 дугаар улиралд багтаан аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулж хувийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулагад хүргүүлнэ.

8.4.Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харъяа холбогдох байгууллага нь шаардлагатай тохиолдолд урамшуулалд хамрагдсан бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал болон тэдгээрийн үйлдвэрлэлийн байдалд харьяа мэргэжлийн хяналтын болон татварын албаар шалгалт хийлгүүлж, шалгалтын мөрөөр холбогдох арга хэмжээ авч шалгалтын дүн тус бүрийг холбогдох тайлбар, нотлох баримтын хамт Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулагад тус тус хүргүүлнэ.

8.5.Урамшуулал болон мөнгөн бус дэмжлэгт хамрагдахын тулд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн баримт бичиг, мэдээллийн үнэн зөвийг тухайн ирүүлсэн этгээд бүрэн хариуцна.

8.6.Энэхүү журмын 8.5-д заасан баримт бичгийг хуурамчаар бүрдүүлснийг эрх бүхий байгууллагаас тогтоосон, хуурамч болох нь илт тодорхой боловч түүнийг хянаж баталгаажуулан урамшуулал, дэмжлэгт хамруулахыг завдсан буюу хамруулсан, дэмжлэгийн хөрөнгийг зүй бусаар зарцуулсан этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх ба үүнтэй холбоотойгоор үүссэн хохирлыг буруутай этгээд хариуцна.

Тариалан эрхлэгчээс бүтээгдэхүүний мөнгөн урамшуулал болон  
мөнгөн бус дэмжлэгт хамрагдах хүсэлт гаргах маягт

20..... оны ..... сарын .....-ны өдөр

1	Аймаг, сумын нэр	
2	Аж ахуй нэгж, иргэдийн нэр	
3	Захирлын овог нэр, регистрийн дугаар	
4	Хаяг, утас, цахим хаяг	
5	Мөнгөн урамшуулалд хамрагдах тохиолдолд банкны нэр, дансны дугаар	
6	Тариалсан талбай /га /	
7	Тариалсан бүтээгдэхүүний нэр, төрөл	
8	Хураан авсан ургац /тн, кг/	
9	Урамшуулалд хамрагдах бүтээгдэхүүний тоо, хэмжээ /тн, кг/	

Эрх бүхий албан тушаалтын нэр

(эсвэл хүсэлт гаргагч иргэний нэр)

Гарын үсэг

Тамга

Жич: Журмын 4.1, 5.1-д заасан баримт материалуудыг энэхүү хүсэлтэд хавсарган  
ирүүлэхийг анхаарна уу.